

## ЯПОНЫ ДОТООД БОЛОН ГАДААД БОДЛОГЫН ТАЛААР

Лу Рэнь

2007 онд Японы улс төрийн нөхцөл байдалд томоохон өөрчлөлт гарсан юм. Дайны дараах консерватив улс төрчдийн шинэ үеийн төлөөлөгч болох Абэ нь дайны дараах тогтолцооноос ангижирч “энгийн улс” болох алхамыг хурдасгах зорилгоор дотоод бодлогынхоо хувьд “үндсэн хуулийн болон боловсролын тогтолцооны шинэчлэл”, “өөрийн зэвсэгт хүчинтэй болох”, гадаад бодлогынхоо хувьд олон улсын тавцанд нэр хүндээ богино хугацаанд дээшлүүлж, улмаар “улс төрийн томоохон хүчин” болохын төлөө дипломатын бүх түвшинд “нийтлэг үнэт зүйлс”-д ач холбогдол өгч, түүнийгээ хэрэгжүүлэх явдалд гол анхаарлаа хандуулжээ. Гэвч түүний дээрхи асуудлуудад анхааралаа хандуулсан явдал нь түүний засгийн газартай холбоотой гарсан цуврал дуулианууд, олон нийтийн санаа бодлоос хамааран чиглэлээсээ хазайсан бөгөөд Абэ нь өөрөө жил хүрэхгүй хугацааны дотор огцроход хүрсэн юм. Харин Фукуда нь ид хямралын үед шинэ албан тушаалаа хүлээн авсан бөгөөд гол анхаарлаа удирдах байр сууриа бэхжүүлэхэд хандуулсан юм. Түүний дотоод болон гадаад бодлого нь илүү прагматик чанартай болсон, гэхдээ түүний байгуулсан засгийн газар нь Японы Ардчилсан намын зүгээс ноцтой сорилтуудтай тулгарсан юм.

### I. 2007 онд дотоод нөхцөл байдал

2007 онд Японы улс төрийн тавцанд эрх баригч нам Парламентийн Дээд танхимын сонгуульд ялагдал хүлээсэн, ерөнхий сайд хугацаанаасаа өмнө огцорсон зэрэг томоохон өөрчлөлтүүд гарсан юм. Фукудагийн Засгийн газар нь Ардчилсан намын зүгээс ноцтой сорилтуудтай тулгарсан бөгөөд нөхцөл байдал нь тийм ч таатай биш байлаа. Дотоодын хэрэгцээ болон экспорт өсөн нэмэгдсэнээр Японы эдийн засгийн өсөлт тогтмолжсон хэдий ч Коизүмигийн бүтцийн шинэчлэлийн алдаа, дутагдалууд нь илрэн гарч ирсэнээр олон нийтийн эдийн засгийн хөгжлийн талаархи сэтгэл ханамж нь буурсан байна.

**1. Абэгийн Засгийн Газар олон нийтийн дэмжлэгийг алдсан явдал нь эрх баригч намыг Парламентийн Дээд танхимын сонгуульд ялагдал хүлээхэд хүргэсэн бөгөөд Японы улс төрийн тэнцвэртэй байдалд томоохон өөрчлөлтүүд гарч ирсэн юм.**

1) Абэ нь дайны дараах тогтолцооноос ангижрах явцыг хурдасгахад ихээхэн хүчин чармайлт гаргасан ч үүнтэй зэрэгцээд түүний бодлогын чиглэл нь олон нийтийн санаа бодлоос хазайсан юм.

Абэ нь Засгийн газраа байгуулсанаараа Коизүмигийн шинэчлэлийн дараах баян, хоосны ялгаа нэмэгдсэн, эдийн засгийн

хөгжлийн тогтворгүй байдал зэрэг үр нөлөөг үл харгалзан “үндсэн хуулийн болон боловсролын тогтолцооны шинэчлэл”, “өөрийн зэвсэгт хүчинтэй болох” зэрэг асуудлуудад анхаарлаа хандуулан “дайны дараах тогтолцоо”-ноос ангижирч “энгийн улс” болох явцыг хурдасгахад ихээхэн чармайлт гаргасан юм. Жилийн эхний хагаст Абэ нь Үндсэн хуулийг шинэчлэх явцын нэгэн чухал алхам болох Үндсэн хуульд өөрчлөлт оруулах анхны бүх нийтийн санал асуулгатай холбоотой хууль батлахыг Парламентаас шаардаж байсан бөгөөд, Их гүрний статустай болох арга замыг эрэлхийлэн, улмаар “энгийн улс” болох зорилгодоо хүрэхийн тулд үзэл суртлын үндэс суурийг бий болгох, үндэсний сэтгэхүйг дахин хэлбэржүүлэх зорилгоор “эх оронч, эзэн хаандаа үнэнч байна” хэмээх үзэл суртлыг үгүйсгэж байсан өмнөх боловсролын философийн эсрэг “эх оронч байдлыг” өнөөгийн боловсролын тогтолцооны зорилго болгон дахин тодорхойлохтой холбоо бүхий хуулийн гурван төслийг батлахыг шаардаж байсан юм. Мөн Япон нь цэргийн асуудал дээр өөрийгөө чөлөөлөх асуудлыг үргэлжлүүлэн хурдасгаж байсан юм. 1-р сард Японы Батлан Хамгаалах Агентлагийг бие даасан яам болгон өргөжүүлэх, үүгээрээ Японы зэвсэгт хүчний улс төрийн статусыг сайжруулахтай холбоотойгоор Абэ нь “нийтийн өөрийгөө хамгаалах эрх”-ийг хориглосон явдлыг цуцлахыг идэвхитэйгээр дэмжиж ирсэн бөгөөд Японы өөрийгөө хамгаалах хүчний АНУ-ын цэргийн үйл ажиллагааг дэмжин сургуулилт хийх асуудал дээр тусгай судалгаа хийх дөрвөн цуврал хурал зохион байгуулсан байна. Абэгийн дээрхи улс төрийн саналуудын үндсэрхэг үзэлтэй холбоо бүхий хэсэг нь консерватив хүчний баруун жигүүрийн дэмжлэгийг хүлээсэн боловч олон нийтийн санаа, бодлоос ихээхэн хазайсан байна. Японд явуулсан олон нийтийн санал бодлын талаархи санал асуулга нь япончуудын хамгийн их санаа зовниж буй асуудлуудыг дараах байдлаар харуулсан байна: Тэтгэвэр (71 хувь), эдийн засгийн сэргэлт (46 хувь), “мөнгө-хүчний улс төр” (38 хувь) гэх мэт. Нийт судалгаанд хамрагдагсдын зөвхөн 30 хувь нь Абэгийн хичээл зүтгэл гарган санаачилсан Үндсэн хуулийн шинэчлэлийн асуудалд санаа зовниж буйгаа илэрхийлсэн байна.

*2) Засгийн газар нь ямар нэгэн зохистой тайлбар хийж чадалгүйгээр дуулианд холбогдсон бөгөөд олон нийтийн дэмжлэг буурчээ.*

2007 оны 7 сард Парламентийн Дээд танхимын сонгууль явагдахаас өмнө дөнгөж, 10 сарын өмнө томилогдсон Абэгийн Засгийн газрын гурван гишүүн эдийн засгийн асуудал, зохимжгүй үг хэллэг ашигласан зэргээс болоод огцроход хүрсэн байна. Абэ нь дээрхи асуудлуудад тохирсон арга хэмжээ авч, үр дүнтэй шийдвэрлэж чадаагүй юм. Ялангуяа Нийгмийн Даатгалын Агентлаг нь 50 сая тэтгэврийн

хавтаст хэрэг алдсан нь тодорхой болсоны дараа олон нийтийн сэтгэл дундуур байдлыг намжаах цагаа олсон, үр дүнтэй арга хэмжээ авч чадаагүй учир дуулиан, шуугиан нэмэгдэж яваандаа Абэгийн Засгийн газрын итгэлтэй ажиллаж байгаа эсэхэд эргэлзсэн хямрал болон хувирчээ. Түүний нэр хүндийн хувь нь 70 хувиас 30 хувь болон буурчээ.

3) *Эрх баригч нам Парламентийн Дээд танхимын сонгуульд гашуун ялагдал хүлээсэн бөгөөд сөрөг хүчний болон эрх баригч намын хүчний тэнцвэрд томоохон өөрчлөлт гарчээ.*

Японд 7 сарын 29-нд Парламентийн Дээд Танхимын сонгууль явагдсан байна. Энэ нь Абэ ерөнхий сайд болж, засгийн газраа байгуулсаны 10 сарын ажлын талаархи олон нийтийн санал бодлын талаар үндэсний судалгаа явагдсанаас хойшхи анхны парламентийн сонгууль юм. Сонгуульд эрх баригч намын хамгийн том өрсөлдөгч нам болох Японы Ардчилсан Нам нь Абэгийн ЗГ-ын талаархи дуулиан, энгийн хүмүүсийн санааг зовоож байсан асуудал болох амьжиргааны түвшингийн асуудлыг ашигласан байна. Японы Ардчилсан Нам нь Либерал Ардчилсан нам болон Шинэ Комейто намын нийт суудлаас илүү тооны суудал авсан бөгөөд түүнээс хойш Дээд Танхимд олонхи болоод байна. Либерал Ардчилсан нам нь “түүхэн ялагдал” хүлээсэн бөгөөд 52 жилийн турш Дээд танхимд олонхи болж ирсэн байр сууриа алджээ. Сонгуулийн үр дүн болсон гол зүйл нь Японы улс төрийн тавцанд эрх баригч болон өрсөлдөгч намууд анх удаа дээд болон доод танхимуудыг удирдан зэрэгцэн орших болсон нь юм.

## **2. Японы Ардчилсан Намын эрх мэдлийг гартаа барих гэсэн оролдлогууд болон Фукудагийн Засгийн газар нь Абэгийн огцорсны дараа ширүүн сорилтуудтай тулгарсан нь**

1) *Японы Ардчилсан Нам нь эрх мэдлийг гартаа авч, эрх баригч намын бодлогод ноцтой шахалт үзүүлэхэд анхаарлаа хандуулсан байна.*

Дээд танхимын сонгуульд ялсаны дараа Японы Ардчилсан Намын үндсэн зорилго нь Либерал Ардчилсан намыг ялж эрх мэдлийг гартаа авах явдал болжээ. Энэ нь улмаар Либерал Ардчилсан намыг чиглэсэн “эцэст нь хүртэл тулалдах”, Дээд танхимд олонхи болсон байр сууриа ашиглан Засгийн газрын цуврал дуулиануудыг гаргаж ирэн Засгийн газраас явуулж буй үйл ажиллагаанд оролцох болтлоо өргөжсөн бөгөөд аль болох хурдан Доод танхимыг тараалгаж, урьдчилсан сонгууль явуулахад чиглэгдэж байсан байна. Японы Ардчилсан Нам нь бусад сөрөг хүчний намуудтай нэгдэх идэвхитэй оролдлогуудыг тусгай стратеги болгон хийсэн бөгөөд эрх баригч намын батлахыг хүсэж байсан “терроризмын эсрэг тусгай арга хэмжээний хууль”-ийг ашиглан засгийн газар руу довтолсоор байлаа. Энэ ширүүн эсэргүүцлийн улмаас “терроризмын эсрэг тусгай арга хэмжээний хууль”

товлосон хугацаандаа батлагдаагүй байна. Японы Засгийн газар нь олон улсын цэргийн хүчинд дэмжлэг үзүүлэх зорилгоор Энэтхэгийн далайд үйл ажиллагаа явуулж байсан хөлөг онгоцуудаа буцаан татахад хүрсэн байна. Японы Ардчилсан Нам Засгийн газрын санаачилсан “терроризмын эсрэг тусгай арга хэмжээний шинэ хууль”-ийг байгаа болгон сонгож авсан бөгөөд Доод Танхимын дараагийн сонгуульд бэлтгэн эрх баригч намтай өрсөлдөөнөө үргэлжлүүлсээр байна.

*2) Абэ өөрийн Засгийн газрын буурч буй чиг хандлагыг эргүүлж чадаагүй тул ерөнхий сайдын хувьд огцроход хүрсэн юм.*

Дээд танхимын сонгуулийн үр дүнд түүний Засгийн газарт тулгарсан хүндрэлүүдээс аль болох хурдан гарахын тулд “эрх баригч намын шинж дүр төрх”-ийг бий болгох зорилгоор Абэ танхимынхаа болон Либерал Ардчилсан Намын өндөр албан тушаалын хүмүүсийн өргөн хүрээг хамарсан сэлгээг хийжээ. Абэ уг сэлгээг явуулахдаа нэр дэвшигчдийн “хувь хүний зарчимч байдал”-д гол анхаарлаа хандуулсан бөгөөд “Мөнгөний улс төр”-д сэжиглэгдсэн бол хэнийг ч тоож үзээгүй байна. Мөн тэрээр аль болох хурдан өөрийн Засгийн газрыг тогтворжуулж, тааламжгүй нөхцлийг эргүүлэх хүсэлтэйгээр танхимынхаа хуучин сайдууд болон ахмад улс төрчдийг гол гол албан тушаалд буцаан томилжээ. Гэсэн ч энэ нь үр дүн багатай байлаа. Танхимаа шинэчлэн зохион байгуулсанаас хойш долоо хоног хүрэхгүй хугацааны дараа хөдөө аж ахуй, ой болон загас агнуурын яамны шинээр томилогдсон сайд нь Засгийн газрын татварын хуурамч мэдүүлэг ашигласан дуулианд орооцолдож огцроход хүрсэн бол төрийн сангуудыг буруу ашигласан хэд хэдэн сайд илэрчээ. Абэ дахиад л буруу хүмүүс ажилд авсан хэмээн буруутгагджээ. “Мөнгө-хүчний улс төр”-ийн асуудалтай дахин дахин тулгарсан, ард түмний итгэл буурах болсон, сөрөг хүчний намуудын зүгээс “терроризмын эсрэг тусгай арга хэмжээний хууль”-ийн талаар үзүүлэх дарамтууд улам чангарах болсоноор Абэ 9 сарын 12-нд огцорсноо зарлахаас өөр аргагүй болсон байна.

*3) Фукуда Засгийн эрхийг хямралтай үед нь авсан бөгөөд түүний захиргааныхан ноцтой сорилттой тулгарсан байна.*

9 сарын 25-нд Засгийн газрын танхимын нарийн бичгийн дарга байсан хянуур, зохион байгуулалт сайтай гэдгээрээ нэртэй Ясуо Фукуда Японы 91 дэх ерөнхий сайдаар томилогдсон байна. “Дотоод, гадаад хүндрэлүүд”, түүний засаг захиргаанд тулгараад буй асуудлуудтай учирсан Фукуда нь Абэгийн эрчимтэйгээр хөгжүүлж ирсэн “Үндсэн хуулийн шинэчлэл” болон олон нийтийн санаа бодлоос хазайсан бусад санаачлагуудыг хойш нь тавьж, жирийн хүмүүсийн санааг зовоож байсан асуудал болох амьжиргааны түвшинд өөрийн Засгийн газрын гол анхаарлыг хандуулсан байна. Тэрээр шинэчлэл болон эдийн засгийн

тогтвортой өсөлтийн зохион байгуулалттай хөгжлийг хангаж чадна, мөн тэтгэврийн асуудлыг шийдвэрлэхэд өөрийн чадах бүхнийг хийнэ гэж хэлсэн бөгөөд нийгмийн халамж, олон нийтийн аюулгүй байдал, эдийн засгийн сэргэлтэнд зориулсан цуврал тусгай арга хэмжээнүүдийг санал болгожээ. Фукуда нь мөн эрх баригч болон сөрөг хүчний намуудыг үндэсний эдийн засаг болон хүн ардын амьжиргааны түвшингийн үүднээс гол гол бодлогуудад анхаарлаа хандуулахыг уриалсанаараа, өрсөлдөгч намуудын хамтын ажиллагаанд хүрэх арга замыг эрэлхийлэх санаачлагыг гаргажээ. Фукуда мөн Либерал Ардчилсан Намын дарга болох Ичиро Озаватай хоёр удаа уулзаж, зөвлөлдөөний механизм бий болгох, эрх баригч, сөрөг хүчний намын эвслийн Засгийн газар байгуулах санал тавьжээ. Озава нь уг саналуудыг сонирхож буйгаа илэрхийлсэн боловч, намынхан нь хүчтэй эсэргүүцэж, түүнийг огцруулах талаар санал асуулга явуулжээ. Озаваг намын дарга хэвээр үлдээсний дараа Либерал Ардчилсан Нам нь эрх мэдлийг гартаа авах тал дээр илүү чанга байр суурьтай болжээ. Эрх мэдлийг гартаа авах гэсэн сөрөг хүчний оролдогуудыг няцаах, иймэрхүү оролдогуудын талаархи Засгийн газрын идэвхигүй байр суурийг эргүүлэх нь Фукудагийн хувьд хүндхэн сорилт болсон байна.

### **3. Эдийн засгийн тууштай өсөлт болон шинэчлэлийн алдаа дутагдалууд илрэн гарч ирсэн нь**

*1) Эдийн засгийн хөгжил нь зарим салбарт бага зэргийн сул байгаа хэдий ч тогтвортой байна.*

2007 онд эдийн засгийн өсөлт харьцангуй сул байсан хэдий ч эдийн засгийн гол үзүүлэлтүүд сайн байсан юм. 12 сард Японы Засгийн газрын танхимаас гаргасан эдийн засгийн мэдээнээс үзвэл 2007 онд Японы ДНБ нь 4.46 тэрбум ам.доллараас давж, эдийн засгийн өсөлтийн жинхэнэ хувь нь 2006 оны 1.7 хувиас арай бага буюу 1.3 хувь, хувийн хэрэглээний зарцуулалт 2.55 триллион ам.доллар буюу 2006 оныхоос 1.3 хувиар өссөн, дотоодын нийт бүтээгдхүүний өсөлт нь жилийн 2.2 хувийн дундаж өсөлтөөс үргэлжлэн өссөөр байна, гадаад худалдааны нийлбэр нь 1.28 триллион ам.доллар, экспорт нь 0.69 триллион ам.доллар, импорт нь 0.59 триллион ам.доллар болсон байна. Ажилгүйчүүдийн тоо 2.55 сая байсан бөгөөд ажилгүйдлийн хувь нь жилийн дундажаас 0.3 хувиар бага буюу 3.9 хувь байна. Гэхдээ нөгөөтэйгүүр Японы эдийн засгийн нь зарим салбарууд нь сөрөг үзүүлэлттэй байна. Үүнд дараах үзүүлэлтүүд голчлон нөлөөлжээ: 2007 онд дампуурсан хувийн хэвшилүүдийн тоо нэмэгдэж 14.901 болсон нь 2006 оны мөн үеийнхээс 846-р илүү байна, барилга угсралт нь жилийн эхний 11 сарын 6-д нь, тоног төхөөрөмжийн захиалга нь эхний 11 сарын 7-д нь сөрөг өсөлттэй байсан байна.

*2) Шинэчлэлийн арга хэмжээнүүдийг эхэлсэн боловч шинэчлэлийн алдаа, дутагдлууд аажмаар тодорхой болсон нь*

Абэ Засгийн эрхэнд гарсныхаа дараа Коизүмигийн бүтцийн шинэчлэлийн чиг шугамыг нь өвлөн авч, түүний эдийн засгийн өсөлтөнд анхаарлаа хандуулдаг байдлыг нь үйл ажиллагааныхаа чиглэл болгожээ. Гэвч Коизүмигийн шинэчлэлийн сөрөг үр дагаварууд нь аажимдаа ил гарч ирэв. Өнөөгийн байдлаар Японы эдийн засаг нь дараалсан хүндрэлүүдтэй тулгараад байна. Засгийн газар болон орон нутгийн засаг захиргааны санхүүгийн байдал маш хүнд байгаа бөгөөд удаан хугацааны өрийн тэнцэтгэл нь 6.66 триллион ам.доллар, 2007 оны санхүүгийн алдагдал нь дангаараа 0.25 триллион ам.доллар болж, баян хоосны болон бүс нутгийн эдийн засгийн ялгаа нь дахин нэмэгдэн, үндэсний орлогын хуваарилалтын коэффициент нь 0.31 хувиар өссөн, харин алслагдмал бүс нутгийн эдийн засаг нь зогсонги байдалд байгаа бөгөөд ажил эрхлэгч хүн амын тоо цөөрсөн, нийгмийн халамжийн сангийн алдагдал ихэссэнтэй холбоотойгоор хүн амын наслалтын болон нийгмийн халамжийн асуудлууд зэрэг нь чухалд тооцогдох боллоо. Засгийн эрхэнд гарсныхаа дараа Фукуда нь “тусгаар тогтнол болон хамтын ажиллагаа” гэсэн улс төрийн уриан доор “залуучуудад найдвар төрүүлсэн, настайчуудад ая тухтай” улсыг бий болгох, үүнийхээ тулд “шинэчлэл болон эдийн засгийн тогтвортой хөгжлийн хоёр дугуйг нэгэн зэрэг хөдөлгөх” хөтөлбөрийг санал болгосон хэдий ч дээрхи асуудлуудыг шийдэх нь тийм хялбар зүйл биш юм.

## **II. Дипломат эрч хүч**

2007 онд Абэ Засгийн газрын тэргүүн байх хугацаандаа Япон-Америкийн харилцааг бэхжүүлэхэд тулгуурласан гадаад бодлогоо, “хөршийн дипломат бодлогоо бэхжүүлэх”, “үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлогоо хөгжүүлэх” хэмээх уриануудтай хамт Японы гадаад бодлогын “гурван багана” болгож ирсэн юм. Тэрээр олон улсын тавцан дахь Японы нэр хүндийг өсгөх, практик сонирхолыг нь өргөжүүлэхэд дипломатын бүх түвшинд анхаарлаа хандуулсан бөгөөд бүс нутгийн болон олон улсын тавцан дээр чухал үүрэг гүйцэтгэсэн байна. Засгийн эрхэнд гарсныхаа дараа Фукуда суларч ирсэн үзэл сурталдаа өөрчлөлт хийн, Абэгээс өвлөж авсан гадаад бодлогийн дагуу “АНУ-ын дипломат” болон “Азийн дипломат”-ын хоорондын уялдаанд илүү ач холбогдол өгөх болжээ.

**1. Япон-АНУ-ын хоорондын харилцаа бэхжиж ирсэн боловч, хоёр талын ялгаа болон зөрчилдөөн нь улам нэмэгдсэн байна.**

Япон өнгөрсөн жилийн турш дипломат бодлогынхоо үндсэн дээр Япон-АНУ-ын холбоог бэхжүүлж ирлээ. Абэ болон Фукуда нь Япон-

АНУ-ын холбоо нь “Японы дипломат бодлогын хамгийн гол цэг” гэдгийг дахин дахин тэмдэглэж байлаа. Фукуда Засгийн эрхэнд гарангуутаа Японы ерөнхий сайд нар хамгийн анхны айлчлалаа АНУ-д хийдэг заншлыг сэргээсэн бөгөөд энэ нь АНУ-тай харилцах харилцаагаа Японы гадаад бодлогын тэргүүлэх чиглэл болгох санаатай байгаа хандлагын илэрхийлэл болжээ. Япон-АНУ-ын хамтын ажиллагаанд нийтлэг стратегийн сонирхолын үндсэн дээр мэдэгдэхүйц ахиц гарчээ. 5 сард болсон “2+2” уулзалтын үеэр хоёр тал “АНУ-Японы аюулгүй байдал болон батлан хамгаалах хамтын ажиллагааг хөгжүүлэх нь” хэмээх хамтарсан мэдэгдэл гаргасан бөгөөд үүгээрээ Ази, Номхон далайн бүс нутгийн аюулгүй байдалд Япон-АНУ-ын хамтын ажиллагаа маш чухал гэдгийг дахин нотлон, олон улсын аюулгүй байдлын шинэ нөхцөлд тохирохуйц өнөөгийн бүс нутгийн болон олон улсын харилцаан дахь стратегийн нийтлэг 11 зорилгыг тодорхойлж, тусгай арга хэмжээнүүдийг дэвшүүлжээ. АНУ-ын зэвсэгт хүчнийг Японд realignment хэрэгжүүлсэнээр хоёр улс нь мөн зохион байгуулалттай ажиллагаа, хамтарсан цэргийн судалгаа, тагнуулын мэдээ солилцох, хамтын пуужингаас хамгаалах тогтолцоо, цэргийн хамтарсан дасгал сургуулилтын тал дээрхи хамтын ажиллагаагаа хөгжүүлж, үүгээрээ Япон-АНУ-ын цэргийн интеграцийн хамрах хүрээг өргөтгөж байгаа юм. Гэхдээ нөгөө талаар Япон-АНУ-ын хамтын ажиллагаан дахь зөрчил болон ялгаа нь хоёр талын харилцан ялгаатай сонирхолтой холбоотой дотоод, гадаад хүчин зүйлээс болоод улам нэмэгдсэн байна. Хойд Солонгосын цөмийн зэвсгийн асуудал дээр Японы тал хулгайлагдсан япон иргэдийн асуудал шийдэгдэх хүртэл Хойд Солонгосоос “терроризмыг дэмждэг” хэмээх тодотголыг салгахгүй байхыг АНУ-аас дахин дахин хүссээр байна. Гэтэл АНУ нь дээрхи шийдвэр нь зөвхөн Хойд Солонгосын цөмийн зэвсгээс татгалзах явдлаас л шалтгаална гэж мэдэгджээ. Харин терроризмтэй тэмцэх хамтын ажиллагааны хувьд Япон нь дотоодын улс төрийн хямралаас болоод Энэтхэгийн далайд АНУ-ын тэнгисийн цэргийг газрын тосоор хангах ажиллагаагаа түр зогсоход хүрчээ. Энэ нь АНУ-ын зүгээс Японд тавьж байсан найдлагыг нь хөсөрдүүлсэн хэрэг болсон бөгөөд АНУ нь энэ байдлыг үл ойлгож байгаагаар илэрхийлэхийн зэрэгцээ Японд үзүүлэх дарамт шахалтаа эрчимжүүлжээ. Үүнээс гадна АНУ-ын зэвсэгт хүчнийг Японд дахин зохион байгуулах төлөвлөгөө хугацаандаа нь хэрэгжих явц нь Окинавагийн орон нутгийн засаг захиргааны хүчтэй эсэргүүцэлтэй тулгарсанаар боломжгүй болж, Ф-12 сөнөөгч онгоцнуудыг АНУ-аас авах асуудал Японы санаархал Сенатын хоригт орсон, АНУ-ын конгресс Японыг “тав тухын эмэгтэйчүүдийн” асуудалд буруутгасан тогтоолыг баталсан зэрэг нь тэдний харилцан итгэлд гарцаагүй сөрөг нөлөө үзүүлжээ. АНУ-д суугаа Японы элчин сайдын үгээр бол 2001 оны 9 сард

Коизүмигийн АНУ-д хийсэн айлчлалаас хойш АНУ-Японы харилцаа нь хамгийн хүнд, анхаарал шаардсан үетэй тулгараад байна.

## **2. Азийн улсуудтай харилцаагаа сайжруулахад анхаарах, Ази, Номхон далайн бүс нутагт нааштай байр суурьтай болох**

Дэлхийн хэмжээнд Азийн улсууд томоохон үүрэг гүйцэтгэх болсон тухайлбал Хятадын үүрэг нэмэгдсэн, ОХУ сэргэж ирсэн, АСЕАН-ы орнуудын эдийн засгийн хөгжил нь Ази, Номхон далайн бүс нутаг дахь хүчний тэнцвэрийг бүрдүүлж байгаа зэрэгтэй холбоотойгоор Япон нь Азийг чиглэсэн дипломат бодлогодоо их анхаарал тавих болсон юм. Засгийн газрын тэргүүн байх хугацаандаа Абэ нь Хятад болон Өмнөд Солонгостой харилцаагаа сайжруулах тал дээр ихээхэн чармайлт гаргасан бөгөөд ОХУ, Энэтхэг болон АСЕАН-ы орнуудтай харилцах харилцаагаа тогтмол хөгжүүлж ирсэн юм. Фукуда Засгийн газрын эрхэнд гарсанаар Ази, Номхон далайн бүс нутагт нөлөөгөө нэмэгдүүлж, АНУ-Японы харилцаанд тэнцвэртэй байр сууринаас оролцох, тэгсэнээр Япон нь Ази болон АНУ-ын дипломат харилцаанд “тэнцвэртэй” улс төрийн хүчин болж чадах учир Азийн орнуудтай харилцах харилцаагаа улам гүнзгийрүүлэх хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн юм.

Анхны алхам нь Хятад болон Өмнөд Солонгостой харилцаагаа идэвхитэйгээр сайжруулж, хөгжүүлэх явдал байсан юм.

Абэгийн Хятадад хийсэн айлчлал, мөн дипломат харилцаагаа тогтворжуулсаны 35 жилийн ойг Хятад-Японы харилцааг сайжруулах чухал боломж мөн хэмээн үзэж Япон нь Хятад-Японы хоёр талын стратегийн харилцаа, хоёр орны хоорондын төрөл бүрийн түвшинд хамтын ажиллагаа, солилцоого хөгжүүлж ирсэн юм. Үүнтэй зэрэгцээд Япон нь Тайваний болон түүхийн холбогдолтой эмзэг асуудлуудыг зүй зохистой шийдвэрлэж чадсан учир, хоёр орон харилцаагаа цаашид сайжруулж, хөгжүүлэх зөв чиглэлдээ ороод байна. Өмнөх сайд нартай харьцуулахад Фукуда нь засгийн эрхэнд гарсаныхаа дараа ажиллах хугацаандаа Ясукуни сүмд очихгүй гэдгээ тодорхой хэлсэн бөгөөд Хятад-Японы харилцааны хөгжлийн ерөнхий дүр төрхийг илүү хялбаршуулан Абэгийн “үнэт зүйлсэд тулгуурласан дипломат”-ын талаар дурдаагүй байна. 2007 оны 12 сарын 27-30-ны хооронд Фукуда Хятадад айлчлал хийсэн бөгөөд хоёр талын стратегийн харилцааг бэхжүүлж, үүгээрээ хоёр орны хоорондын харилцаа цаашид зөв чиглэлээр хөгжих явдлыг бататгаж өгчээ. 2007 онд Япон-Өмнөд Солонгосын харилцаа мөн тогтвортой хөгжлийн замдаа орсон байна. Хоёр тал нь олон талын болон хоёр талын хамтын ажиллагаагаа илүү идэвхижүүлсэн байна. Тухайлбал, Ли Мун Бак нь 2007 оны 12 сард Өмнөд Солонгосын Ерөнхийлөгчөөр сонгогдсон бөгөөд үүнийг хоёр улсын харилцаа



сайжрах цаашдын чиг хандлагыг харуулж буй сайхан явдал хэмээн хүлээж авчээ. Япон-Хойд Солонгосын харилцаанд ч Фукудагийн Засгийн эрхэнд гарсныхаа дараа дэвшүүлсэн “хэлэлцээр болон шахалтыг зэрэгцүүлэн” хэмээх бодлогын үр дүнд зарим нааштай хандлагууд гарчээ.

Хоёр дахь алхам нь АСЕАН-тай бүх түвшинд харилцаагаа сайжруулах явдал байсан юм.

АСЕАН-ы орнуудын эдийн засгаа хөгжүүлэх, бүс нутгийн харилцаанд тэргүүлэх байр суурьтай болох хүсэлд нь зохицуулан Япон нь “анхаарал тавих болон хуваалцах” гэсэн чиглэлээр АСЕАН-ыг чиглэсэн бодлогоо явуулсан бөгөөд АСЕАН болон түүний гишүүн орнуудтай бүх түвшинд улс төр, эдийн засгийн харилцаагаа өргөжүүлэх зорилгоор эдийн засгийн тусламжаа нэмэгдүүлж, уламжлалт бус аюулгүй байдлын хүрээнд хамтын ажиллагаагаа идэвхижүүлсэн байна. 2007 онд Абэ болон Фукуда нь Филиппин, Индонези, Малайз, Сингапурт амжилттай айлчилсан бол Тайланд, Лаос, Бруней, Камбож, Вьетнамын удирдагч нар мөн ээлж, дараалан Японд айлчилжээ. Япон нь Тайланд, Бруней, Камбож болон Индонезитэй эдийн засгийн хамтын ажиллагаа, хөрөнгө оруулалтын гэрээнд гарын үсэг зурж, эдийн засгийн хамтын ажиллагаа нь шинэ түвшинд гарч буй гэдгийг нь илэрхийлсэн эдийн засгийн түншлэлийн хэлэлцээрийг АСЕАН-тай байгуулжээ. Мөн Япон нь Малаккын хоолойд тэнгисийн аюулгүй байдлыг хангах зорилгоор Тайланд, Малайзи болон Индонезитэй хамтарсан цэргийн сургуулилт болон бусад сургалтын үйл ажиллагааг явуулжээ.

Гурав дахь алхам нь Япон-ОХУ болон Япон-Энэтхэгийн харилцааг хөгжүүлэх явдал байв.

2007 оны туршид Япон-Орос удаа дараагийн дээд түвшний айлчлалууд харилцан хийсэн байна. ОХУ-ын Ерөнхий сайд, Ерөнхий сайдын орлогч, Гадаад хэргийн сайд нар Японд дараалан айлчилсан бол Японы гадаад хэргийн сайд Оросод хоёр удаа айлчилсан байна. Мөн хоёр улс анх удаа дэд сайд нарын түвшинд яриа, хэлэлцээр хийсэн байна. Дөрвөн арлын асуудлаарх хэлэлцээрээ үргэлжүүлэх зуураа тэд мөн эрчим хүчний салбарт хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, Алс дорнодын болон бусад бүс нутгийн хөгжил дэвшилд анхаарлаа хандуулж, Сахалины газрын тос болон байгалийн хийн төсөл, Номхон далайн газрын тосны хоолойн асуудал дээр нэгдсэн тохиролцоонд хүрч чадсан байна. Мөн Япон нь Энэтхэгийг үнэт зүйлсэд тулгуурласан дипломат бодлого, аюулгүй байдлын хамтын ажиллагаагаа өргөжүүлэх гол түнш хэмээн тодорхойлж, хоёр орны харилцааг сайжруулах тал дээр ихээхэн зүтгэл гаргажээ. 2006 оны 12 сард Энэтхэгийн Ерөнхий сайдын Японд хийсэн айлчлал, хоёр талын “стратегийн глобал түншлэл”-ийн дараа Абэ 2007 оны 8 сард олон тооны төлөөлөгчдийн

хамт Энэтхэгт айлчилж стратегийн түншлэлийг хөгжүүлэх “замын төлөвлөгөө”-нд гарын үсэг зурсан байна. Айлчлалынхаа үеэр тэр хоёр орны стратегийн нийтлэг ашиг сонирхол, нийтлэг үнэт зүйлсийн үндэс суурийг онцолж үзсэн байна. Япон нь Энэтхэгт 5 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийж, Дели-Бомбейн аж үйлдвэрийн бүс мэтийн дэд бүтцийн барилгажуулалт хийхэд нь зориулж 3 сая ам.долларын зээл олгоно гэдгээ амалсан байна.

### **3. “Нийтлэг үнэт зүйлс”-ийн үндсэн дээр хоёр талт болон олон талт аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэх**

Бүс нутгийн аюулгүй байдлын нөхцөл байдал өөрчлөгдсөн, Америкийн стратегийн хүч чадал харьцангуй буурсантай холбоотойгоор Япон нь АНУ-Японы хамтарсан аюулгүй байдлын тогтолцоог хадгалж үлдэхийн зэрэгцээ “нийтлэг үнэт зүйлс”-ийг шинэ чиглэл болгон Австрали, Энэтхэгтэй аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэх болсон юм. Үүний үндсэн дээр Япон нь АНУ-Япон-Австрали, Япон-АНУ-Энэтхэг гэсэн аюулгүй байдлын хамтын ажиллагааны гурван талт бүтцийг бий болгосон бөгөөд Австрали, Япон, АНУ, Энэтхэг улсуудын хамтыг ажиллагаанд чиглэсэн бүс нутгийн шинэ аюулгүй байдлын механизм бий болгохыг санал болгожээ. Хоёр талт харилцааны түвшинд бол Япон-Австрали нь 9 үндсэн төсөл, 3 салбар, аюулгүй байдлын хамтын ажиллагааны 4 арга замыг тодорхойлж, улмаар хоёр орны хоорондын аюулгүй байдлын хамтын ажиллагааны үндсэн бүтцийг тодорхойлох зорилгоор 2007 оны 3 сард Аюулгүй байдлын хамтын ажиллагааны хамтарсан Тунхаглалд гарын үсэг зурсан байна. 6 сард Австрали, Япон нь анх удаа “2+2” уулзалт хийж, цаашид холбоотон болох чиглэлээр хоёр талт аюулгүй байдлын хамтын ажиллагааны хөгжлийг тодорхойлж буй хамтын ажиллагааг хөгжүүлэн, тунхаглалыг хэрэгжүүлэх бодит арга хэмжээнүүдийг санал болгосон байна. Япон болон Энэтхэг нь батлан хамгаалах талаархи зөвлөгөөнөө генералуудын түвшинд тогтмол үргэлжлүүлсээр байгаа бөгөөд дэд сайд нарын түвшинд байсан батлан хамгаалахын бодлогын уулзалтыг сайд нарын түвшингийнх болгожээ. Тэдний сайд нарын түвшингийн анхны стратегийн яриа хэлэлцээр, батлан хамгаалахын сайд нарын хэлэлцээр нь 2007 оны 3, 6 сард болсон байна. Гурван талт харилцааны түвшинд Япон, АНУ, Австрали нь дэд сайд нарын түвшингийн гурван талт стратегийн хэлэлцээр, гадаад хэргийн сайд нарын ажлын түвшингийн тогтмол зөвлөлгөөнүүдийг хийсээр байна. Тэд мөн анхны батлан хамгаалахын сайд нарын гурван талт уулзалтыг 6 сард, анхны гурван талт дээд хэмжээний уулзалтыг 9 сард, цэргийн анхны хамтарсан сургуулилалтийг 2007 оны 10 сард Кюүшюүгийн баруун хэсгийн усанд хийжээ. Мөн 2007 оны 4 сард Ёкосугагийн өмнөд хэсгийн усанд Япон,

АНУ, Энэтхэг нь цэргийн анхны хамтарсан сургуулилтийг хийжээ. 4 талын түвшинд Япон, АНУ, Австрали, Энэтхэг нь 2007 оны 5 сард Маниллад, АСЕАН-ы бүс нутгийн форумын удирдах албан тушаалтнуудын уулзалтан дээр албан ёсоор дөрвөн талын аюулгүй байдлын хамтын ажиллагааг хөгжүүлэхээр болсон, 2007 оны 9 сард Бенгалийн буланд Сингапурын хамт таван улсын анхны хамтарсан цэргийн сургуулилт хийх болсоноо зарлахаар генералуудын анхны уулзалтыг явуулжээ. Засгийн эрхэнд гарсныхаа дараа Фукуда Абэгийн гадаад бодлогын үзэл суртлын зарчмыг бага зэрэг сулруулсан хэдий ч хоёр болон олон талт түвшинд аюулгүй байдлын хамтын ажиллагааны механизм бий болгох ажлыг үргэлжлүүлэн ажилласаар байна.

#### **4. Эрчим хүч болон “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд гишүүнээр элсэхэд” анхаарлаа хандуулан Африк, Ойрхи Дорнод, Төв Азийг чиглэсэн дипломат бодлогоо идэвхижүүлсэн нь**

2007 онд олон улсын эрчим хүчний зах зээлийн байдал хурцадсанаар Япон нь эрчим хүчний хангамжаа тогтвортой болгох үүднээс идэвхитэй эрчим хүчний дипломат бодлого явуулсан бөгөөд үүний зэрэгцээ НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлийн шинэчлэл хойшлуулгдсоноор “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд гишүүнээр элсэх” болон бусад улсуудын зүгээс хүртэх улс төрийн дэмжлэгийг авахаар ихээхэн хүчин чармайлт гаргасан байна.

Эхнийх нь Африкт үзүүлэх тусламжаа нэмэгдүүлэх явдал байсан юм.

Япон нь “НҮБ-ын Аюулгүйн зөвлөлд гишүүнээр” элсэхэд зориулан Африкийн орнуудыг дэмжиж байгаа бөгөөд үзүүлж буй эдийн засгийн тусламжаа тухайн нутгийн элчин сайдын яам, консулын газруудаараа дамжуулан олон улсын байгууллагуудад чухал байр суурьтай болох, Аюулгүйн зөвлөлийн байнгын бус гишүүн болох зорилгодоо ашиглаж байна. Япон нь улмаар “эргүүлэн төлөх чадвартай субъектэд тусламж үзүүлнэ” хэмээх зарчмаа хянаж үзсэн бөгөөд 11 сард Африкийг чиглэсэн дипломат бодлогодоо шинэ чиг шугамыг боловсруулжээ. Энэ нь эхлээд ерийн хямралд байгаа боловч газрын тос, хийн нөөцөөр баялаг Анголд иений зээл олгох, мөн төлбөрийн чадваргүй боловч зэс, никелийн нөөцөөр баялаг Мадагаскар, Замбид иений зээл олгох эрхийг нь сэргээх, Африкийн зүүн, төв хэсгийн томоохон зохион байгуулагч болох Кенийн Момбас дахь төслөө хэрэгжүүлэхэд нь зориулж 27 тэрбум иений зээл олгохоор төлөвлөөд байна.

Хоёр дахь нь “газрын тос болон байгалийн хийн айлчлал”-ыг Ойрхи дорнодод хийх явдал байсан юм.

2007 оны 4-5 сарын хооронд Абэ 180 хүнээс бүрдсэн бизнес бүрэлдэхүүнийг толгойлон Ойрхи дорнодын Саудын Араб, АНЭмират, Кувейт, Катар, Египет гэсэн 5 орноор айлчилжээ. Айлчлалынхаа үеэр Абэ нь Окинавад байрладаг Японы улсын хөрөнгө оруулалттай газрын тосны агуулахуудыг ашиглан “газрын тос нөөцлөх төлөвлөгөө”-г хэрэгжүүлэхийг санал болгосон байна. Абэ дээрхи таван оронтой газрын тосны болон бусад салбаруудад засгийн газар, иргэний нийгмийн хүчин чармайлтыг хослуулан хамтын ажиллагаагаа хөгжүүлэх, олон түвшинд эдийн засгийн харилцааг хөгжүүлэн эрчим хүчний тогтвортой хангамжийг бий болгохыг санал болгожээ.

Гурав дахь нь Төв Азитай цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх явдал юм.

“Япон-Төв Ази” харилцааны механизмыг хэвээр нь байлгах, газрын тос болон байгалийн хийн хамтын ажиллагааг хөгжүүлэх зорилгоор Япон нь Төв Азитай цөмийн эрчим хүчний хамтын ажиллагааг хөгжүүлэх санаачилгаа нэмэгдүүлжээ. 2007 оны 4 сард Японы Эдийн засаг, Худалдаа болон Үйлдвэрийн яамны сайдаар толгойлуулсан 150 хүнээс бүрдсэн томоохон бизнес бүрэлдэхүүн дэлхийд ураны нөөцөөрөө 2-т болон 10-т жагсдаг Казахстан, Узбекистанд айлчилжээ. Япон нь энэ хоёр улстай цөмийн эрчим хүчний хамтын ажиллагаагаа хөгжүүлэх хэлэлцээг байгуулжээ. Бусад орнуудтай харьцуулахад Япон нь Казахстанас авах ураныхаа импортыг үлэмж нэмэгдүүлэх бөгөөд Казахстанас импортлох уран нь нийтдээ өнөөгийн 1 хувиас 30-40 хувь болж нэмэгдэх юм.

*“International strategic studies” сэтгүүлийн 2008 оны №2 дугаар*

*Англи хэлнээс орчуулсан: Т.Амгалан (ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан)*